



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/427

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүрмийн 3.4.2.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2.5, 2.13 дахь заалтууд, Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 03/1071 тоот албан бичгээр өгсөн чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 01 дүгээр тогтоолын дагуу хэрэгжүүлж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын /ОУИТБС/-ын 2022 оны тайланд аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу “ОУИТБС-ын нэгтгэл тайланд аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг улирал бүр ОУИТБС-ын Ажлын албанд хүргүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Г.Гантулга)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар (Э.Түвшинжаргал)-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124017093



“Эрдэнэс Тавантолгой” ХХ-ийн
Гүйцэтгэх захирлын албан тушаалтан
Д. Энхжаргал

ОУИТБС-ын нэгтгэл тайланд аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

ДД	ОУИТБС-ын 17 дугаар нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх ажилтан	Хяналт тавих албан тушаалтан	Хэрэгжүүлэх хугацаа
1	Нэгтгэлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд ил тод байдлын тайлангаа алдаагүй бүрэн баталгаажуулж ирүүлэх талаар АҮЭБЯ, СЯ болон холбогдох бусад байгууллага онцгой анхаарал хандуулж ажиллах	Компанийн ил тод байдлын тайланг алдаагүй гаргах асуудлаар холбогдох дээд байгууллагуудаас ирүүлсэн үүрэг даалгавар, тушаал шийдвэрийг хэрэгжүүлж хамтарч ажиллах	Д.Буянхишиг	Д.Энхжаргал	Жилийн турш
2	Компаниуд ОУИТБС-ын тайланг өгөх үйл явцад чанарын өөрчлөлт авчрах, хэвшүүлэх, тайлангийн үнэн зөв байдлыг хангахад ахиц дэвшил гаргаж ажиллах	Компанийн ил тод байдлын тайланг батлагдсан маягтын дагуу алдаагүй, үнэн зөв гарган баталгаажуулж хүргүүлэх	Д.Буянхишиг	Д.Энхжаргал	2025.04.01
3	ОУИТБС-ын шаардлагуудын хэрэгжилтийн мэдээллийг ТӨААН-үүдээс бүрэн авах үйл явц тодорхойгүй байгаа тул стандарт, шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах	Компанийн ОУИТБС-ын тайлан, Засгийн газрын байгууллагуудын мэдээлэл хооронд зөрүү үүсэж буй асуудлын шалтгаан, түүнийг хэрхэн арилгах талаар ОУИТБС-ын Ажлын албанаас зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдах, мэдээлэл солилцох	Б.Галбадрах Д.Буянхишиг	Д.Энхжаргал	Тухай бүр
		Тайланг үнэн зөв гаргах, тайлагнах асуудлаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтарч ажиллах	Д.Буянхишиг	Д.Энхжаргал	Тухай бүр
		Стандарт шаардлагуудын хэрэгжилтийг хангаж ажиллах	Д.Буянхишиг	Д.Энхжаргал	Жилийн турш